



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/537

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөл оруулах тухай хууль, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 33 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад батлагдсан сум, багийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах хөтөлбөр арга хэмжээний 500,000,000 төгрөг (Таван зуун сая)-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулагдах 500,000,000 төгрөг (Таван зуун сая) -ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт данснаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга хэмжээний гүйцэтгэлийн явцын тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 26-3  
Zah A/537 tum